

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2026 оны 5 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-2

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 3-19

---

**1.Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжиж буй бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын даргын мэдээллийг сонсох** 3-19

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны  
5 дугаар сарын 05-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 5 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 30 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Тасалсан: Ц.Баатархүү, Ж.Ганбаатар;

**Нэг.Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжиж буй бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын даргын мэдээллийг сонсох**

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Э.Сугарбаяр, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, мөн газрын Бодлого, зохицуулалтын газрын дарга А.Гэрэлзаяа, Зээл, төслийн газрын дарга Н.Энхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Галсанбат, Хяналт шалгалтын газрын референт Д.Мөнхтуяа нар байлцав.

Мэдээллийг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, О.Батнайрамдал нарын тавьсан асуултад Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, мөн газрын Бодлого, зохицуулалтын газрын дарга А.Гэрэлзаяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжиж буй бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын дарга Я.Эрдэнэсайханы мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 13 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 57 минут үргэлжилж, 5 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 27 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ  
ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2026 оны 5 дугаар сарын 05-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим  
12 цаг 30 минут.

### **ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**О.Батнайрамдал:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг бас айлтгая.

Дэд хорооны гишүүдийн олонхын ирц хүрэлцэн ирсэн тул Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны 2026 оны 5 сарын 5-ны өдрийн хуралдаан нээгдэж байна. Гишүүдийнхээ ирцийг бас танилцуулчихъя.

Хүрэлцэн ирсэн Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбаагийн Сэддорж, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг, Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал гэж 3 гишүүн хүрэлцэн ирснээр 60 хувийн ирцтэйгээр өнөөдрийн хуралдаан нээгдсэнийг мэдэгдье. Мөн бас ирц танилцуулж дууслаа.

Дэд хорооны хуралдаанаар өнөөдрийн хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжиж буй бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг сонсоно.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор өөр саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжиж буй бодлого, цаашид авч болох арга хэмжээний талаарх мэдээллийг танилцуулна.**

Өнөөдөр хүрэлцэн ирсэн бас энэ сэдэвтэй холбоотой хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг бас танилцуулъя.

Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын дарга, Гэрэлзаяа Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын Бодлого, зохицуулалтын газрын дарга, Энхтөр Жижиг, дунд үйлдвэрийн газрын Зээл, төслийн газрын дарга, Сугарбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч гэсэн хүмүүс хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайд хүрэлцэн ирэх байсан боловч гадаад Элчин сайдуудтай өнөөдөр уулзалтууд хийж байгаа. Яг

тохирч таарсан байна лээ. Тэгэхээр өнөөдөр Төрийн нарийн хүрэлцэн ирсэн байгаа яамаа төлөөлөөд.

Гишүүдэд Жижиг, дунд үйлдвэрлэлийн газраас бэлтгэж ирүүлсэн мэдээллийг бас тараасан байгаа. Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжиж буй бодлого, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын дарга Эрдэнэсайхан дарга танилцуулга хийе. Эрдэнэсайхан даргыг индэр дээр урьж байна.

**Я.Эрдэнэсайхан:** Дэд хорооны эрхэм гишүүд та бүхний энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Жижиг, дунд үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, өнөөгийн нөхцөл байдлыг та бүхэндээ бэлтгэсэнээ товч танилцуулъя.

Хууль, эрх зүйн орчны хувьд бол 2019 онд Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль батлагдсан. Ингээд 2020 онд Засгийн газраар Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлүүлэх, хяналт тавих энэ журам батлагдаж ингээд хэрэгжиж байгаа.

Ингэснээр бол зээлийн хүү буурч байгаа, хүртээмж нэмэгдэж байгаа, даатгалын тогтолцоог оруулж ирж байгаа. Мөн хуучин шүүмжлэл байсан цаасны төсөл олгогддог байсныг бол арилгасан. Ингээд жинхэнэ эзэндээ өнөөдөр олгогдоод явж байгаа. Мөн үйл ажиллагаагаа цахимжуулсан байгаа.

Мөн Жижиг, дунд үйлдвэрийн газрын хувьд бол хоршооны асуудлыг бас хариуцдаг. Хоршоо өөрөө жижиг, дунд үйлдвэрлэл гэдэг дотор ордог. ХХК, хоршоо, нөхөрлөл ороод явдаг. Ингээд Хоршооны тухай хуулийг бол 2021 онд Их Хурлаар батлуулсан. Их Хурлын тогтоол гарсан. Энэ хүрээнд 21, 22 онуудад бол Улсын шилдэг хоршоо шалгаруулах журам Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам, Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам. Энэ тайлангаа бэлдэх зааврыг бол Сангийн сайд болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар батлуулаад ингээд холбогдох эрх зүйн орчин бол бүрдээд ингээд хэрэгжээд ажиллаж байна.

Мөн Жижиг, дунд үйлдвэрийн үйлчилгээг дэмжих тухай хуулиар экспортод бараа, бүтээгдэхүүнээ гаргасан дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн хүүгийн татаас олгох ийм журмыг батлуулах үүргийг бол хуулиар өгөгдсөн. Үүнийхээ дагуу Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар батлуулаад Сангийн сайдад хүргүүлсэн. Ингээд өнөөдөр хүртэл бол батлагдаагүй байгаа. 3, 4 жил болж байна. Яагаад вэ гэхлээр энэ зээлийн хүүг нь өгөх мөнгө байхгүй гэдэг шалтгаанаар бол журам батлагдахгүй бас нэлээдгүй хугацаа өнгөрсөн.

Ингээд 25 онд Аж үйлдвэржилтийн байнгын хорооноос бол “Засгийн газарт чиглэл өгөх тухай” ийм тогтоол батлагдсан. Энэ хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ийм үүрэг чиглэл өгсөн. Энэ дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал гараад хуулийн төслийг бэлдээд ингээд хүргүүлээд байгаа.

Мөн 2026 оны 4 сарын 15-ны Засгийн газрын хуралдаанаар энэ Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангаас өгч байгаа энэ зээлийн хугацааг сунгах, зээл олголтын нөхцөлийг багасгах, шат дамжлагыг багасгах, мөн өмнө олгосон зээлдэгчдийн зээлийн хугацааг зөрчилгүй тохиолдолд 2 жилээр сунгах, зөрчилтэй тохиолдолд зөрчлийг арилгуулах гэсэн ийм үүрэг чиглэл өгсөн. Үүний дагуу сайдын тушаал батлагдаад ингээд бид хэрэгжилтээ хангаад өнөөдөр ажиллаж байна.

Мөн Хоршоо хөгжүүлэх сангийн талаар буюу Монгол Улсын 330 сумд байдаг Хоршоо хөгжүүлэх сангийн талаар эргэн төлөлтийг нь сайжруулах сайдын албан даалгавар ингээд бэлэн болоод өнөө, маргаашгүй батлагдахад бэлэн болоод ажиллаж байна.

Өнөөдөр ер нь 25 оны жилийн эцсийн статистикаар Монгол Улсад 110 мянган аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүний 82 мянга нь буюу 74 хувь нь бол жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч байгаа. Үүний 58 мянга нь нийслэлд, 23 мянга нь бол орон нутагт байгаа. Үүний 93.7 хувь нь бол бичил, 6.1 нь жижиг, 0.2 хувь нь бол дунд гэсэн ангилалд байгаа юм.

Монгол Улсад ажил, хөдөлмөр эрхэлж байгаа сая 300 мянган хүний бол 555 мянга нь бол жижиг, дунд үйлдвэрийн салбарт буюу 40 хувь нь бол энэ салбарт ажиллаж байна.

Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулиараа ямар бодлого баримтлах юм бэ гэхлээр санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгийг үзүүлнэ гээд. Санхүүгийн дэмжлэгийг бол Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Зээлийн батлан даалтын сан, Хоршоо хөгжүүлэх сан, олон улсын төсөл, хөтөлбөр гэдэг ийм институцээр бол санхүүгийн дэмжлэгийг үзүүлж байгаа.

Санхүүгийн бусад дэмжлэгийг бол зөвлөх үйлчилгээ, бизнес инкубатор төв, хүний нөөцийн сургалт, борлуулалт, маркетинг гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж дэмжлэг үзүүлж байна.

Ер нь Жижиг, дунд үйлдвэрийн газар 20 оны 8 сарын 12-нд Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан. Анх бол 1993 онд Үйлдвэр худалдааны яаманд Жижиг, дунд үйлдвэрийн хэлтэс байгуулагдаад үүнээс хойш бол Хөдөлмөрийн яам, Аж үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зэрэг олон яамд ингээд дамжиж яваад 20 онд агентлаг байгуулагдсан.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан 2009 оноос хойш бол нийтдээ улсын төсөв, Засгийн газрын бонд, Хөгжлийн банкны бонд, Чингис бонд гээд нийтдээ 753 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн. Энэ эх үүсвэрийнхээ тодорхой хувийг дахин зээлдүүлэх замаар 9293 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид 1.1 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байгаа юм. 20 оноос хойшоогоо бол нийтдээ 185 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг эргэн төлөлтөөсөө, 29 тэрбум төгрөгийг бол орон нутгаас, төсөл, хөтөлбөрөөс 8.6, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам буюу төсвөөс 7.6 ингээд 189 тэрбум төгрөгийг бол эх үүсвэр бүрдүүлээд байгаа юм.

Ингэхдээ бид тухайн жилд зээл олгох салбар, чиглэлийг тогтоохдоо бол Монгол Улсын төрөөс баримталж байгаа бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал, Цагаан алт, Улсын Их Хурлаас баталсан загвар

хоршоо, тэгээд мөн Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөдөлгөөн, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хөдөө орон нутаг руу шилжих энэ шилжилтийг дэмжих гэх мэтчилэн төрөөс баримталж байгаа бодлогууд, тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа хамтарсан санхүүжилтийн эх үүсвэрийг бол орон нутгийн Засаг даргын саналыг үндэслэж, салбар чиглэлийг салбарын сайд тогтоож ингэж явж байгаа.

Ингээд үзэхээр бол түрүүний хэлсэн Хүнсний хувьсгалд гэхэд бол 764 төсөлд 98.6 тэрбум төгрөгийн хүнсний үйлдвэр, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ, энэ салбарт ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдэд бол олгосон байна.

Цагаан алт буюу ноос ноолуур, арьс ширэн дээр бол 79 төсөлд 7.5 тэрбум төгрөгийг олгосон байна. Загвар хоршоон дээр бол 100 төслийг 10 тэрбум төгрөг, орон нутагт шилжсэн аж ахуйн нэгжийг дэмжихэд бол 28 төсөлд 3.4 тэрбум, “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд бол 19 төсөлд 1.9 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байгаа. Энэ хугацаанд 35 мянган төсөл ирсэн. 35 мянган төсөл ирсэн. Эндээс бол 5.9 их наядын хүсэлтээс бид 1200, 300-ынх нь л зээлийг олгосон гэсэн үг.

Тэгэхээр хүсэлтийн санхүүжилтийн бол 18.6 хувь, аж ахуйн нэгжийн бол 26 хувийнх нь асуудал шийдэгдэж байгаа. Энэ бол нийт хүсэж байгаа зээлдэгчийн тоо биш. Тухайн жилдээ бид нар зөвхөн ноос, ноолуурт өгнө гэвэл ноос, ноолуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаад л аж ахуйн нэгжийн хүсэлт өгнө. Жишээлбэл, мод гэдэг юм уу, эсвэл арьс ширэнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж өгөхгүй.

Тэгэхээр зөвхөн тэр жилдээ олгосон салбар, чиглэлийн хүрээнд хүсэлт авахад ийм байгаа юм. Бид нарын судалгаагаар бол ер нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн жилийн зээл, санхүүжилтийн хэрэгцээ бол 2 их наяд арилжааны банкттай нийлээд. Тэгэхээр энэ санхүүжилтийн бол 0 аравны хэдэн хувийг нь ч бид нар хангаж чадахгүй байгаа гэсэн үг. Тэгэхээр нийт санхүүгийн хүсэлтийн маш бага хувийг хангаж байгаа гэсэн үг.

Гэхдээ бид нар бас тодорхой үр дүнд хүрээд явж байна. Өнгөрсөн жилүүдэд энэ Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангаас 9293 ЖДҮ-д зээл олгосноор 56 мянган ажлын байр шинээр бий болсон. 41 мянган ажлын байр хадгалсан. 6900 үйлдвэр өргөтгөсөн, 2300 үйлдвэр, үйлчилгээ шинээр бий болсон. Ингээд энэ үйлдвэрүүд шинээр бий болж, энэ ажлын байр бий болсноор бол жил бүр улсын төсөвт нийгмийн даатгалын шимтгэлээр 185 тэрбум төгрөг, татвараар бол 124 тэрбум. Ингээд үр өгөөж нь улсын төсөв дээр 300-гаад тэрбум төгрөгийг бол жил болгон ингээд өгөөжөө өгөөд явж байгаа. Тэгэхээр энэ бол үр дүнтэй юм гэдэг нь харагдаж байгаа юм.

Ингээд орон нутгийн эх үүсвэр бол маш үр дүнтэй гэдгийг түрүүн хэлсэн. Ингээд жил болгон 21 оноос хойшоо бол аймаг, орон нутагт орон нутгийнхаа төсөв дээр санхүүжилт тавиач ээ гэдэг ийм хүсэлтийг хүргүүлдэг. Хамгийн анх бол Өмнөговь аймаг, Сүхбаатар аймаг 2 бол хөрөнгө хуваарилаад ингэж эхэлж байсан бол өнөөдөр 11, 2 аймаг, 1 сум санхүүжилт хуваарилдаг болсон байна.

Энэ жилийн хувьд бол Говьсүмбэр, Өмнөговь, Дорнод, Орхон, Сүхбаатар, Увс, Хэнтий, Өмнөговийн Ханбогд сум, Архангай, Дархан-Уул, Дундговь, Төв, Ховд

гэсэн аймгуудад бол зээл олгохоор бид нар бэлтгэл ажлыг хангаад ажиллаж байна.

Говьсүмбэр Өмнөговь аймгийн хувьд бол 4 сарын 6-наас 5 сар ингээд.../минут дуусав./

**О.Батнайрамдал:** Байж байгаарай, микрофон өгөөрэй нэмж. Цаг дуусчих шиг боллоо гэхэд нэмэлт цаг өгье.

**Я.Эрдэнэсайхан:** Дорнод, дараачийн 5 аймаг дээр бол 4 сарын 20-ноос 5 сарын 19-нд зарлаад материалаа цахимаар хүлээж аваад ингээд явж байна. Дараагийн 5 аймаг бол гэрээ байгуулах аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Жижиг, дунд үйлдвэрийн агентлагийн дарга 3-ын гуравласан гэрээгээр зээл олгох салбар, чиглэл, хүүгээ тогтоодог. Үүгээрээ гэрээ нь байгуулагдах шатандаа явж байна.

Энэ хамтарсан санхүүжилт бол маш үр дүнтэй. Өөрөөр хэлбэл, орон нутгаасаа эх үүсвэр бүрдүүлдэг. Сонгон шалгаруулалтыг хамтарч хийдэг, хяналтыг хамтарч бас тавьдаг учраас зээл бол эзэндээ очдог, эргэн төлөлт нь маш сайн байгаа. 20 оноос хойш олгож байгаа зээлүүд бол өнөөдөр эрсдэл үүсээгүй. Одоо бид нарын өнөөдөр эрсдэж байгаа зээлүүд бол дандаа 19 оноос өмнөх зээлүүд байгаа.

Гэхдээ бид нар 19-өөс 22 оны хооронд бол 123 тэрбум төгрөгийн бусдад төлөх өртэй ийм байгууллага буюу санг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хүлээж авсан. Ингээд 123 тэрбум төгрөгийг Засгийн газрын бонд, Хөгжлийн банкны бонд, Чингис бондын өрөнд төлсөн. Өнөөдөр энэ байгууллага өргүй.

Гэхдээ бид нар нийтдээ энэ үед бол мөнгөн хөрөнгөөр болон мөнгөн бус хөрөнгөөр бол арилжааны банкнаас жишээлбэл Капитал банкнаас, тэгээд зээлдэгчдээс бол хөрөнгийг барагдуулж ажиллаж байна.

Мөн бид нар зээл олгох нэг үйл ажиллагаа явуулдаг. Дээрээс нь түрүүний хэлсэн санхүүгийн бус дэмжлэг буюу зах зээл, борлуулалтыг нь дэмжих ийм арга хэмжээг зохион байгуулдаг. Дотоодын 36 үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулахад бол 5300 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцож, 54 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Гадаадын 29 үзэсгэлэн, арга хэмжээ зохион байгуулж, 1800 аж ахуйн нэгж оролцож, 11.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Энэ бол гол төлөв экспортод чиглэсэн аж ахуйн нэгжүүд байгаа. Үүнээс гадна бид нар Америк, Канад, Герман, Хятад гэсэн 4 улсад бол байнгын ажиллагаатай дэлгүүрийг хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулаад менежментийг нь бол хувийн хэвшил авч явж байгаа. Энд Монголын үйлдвэрлэгчид тус тусдаа борлуулалтаа хийх биш зөвхөн үйлдвэрлэлдээ анхаараад борлуулалтыг нь дэмжих тэр хувийн хэвшлийн компани энд ингээд дэлгүүр ажиллуулаад ингээд явж байгаа.

Мөн өнгөрсөн хугацаанд бол 450 гаруй сургалт, зөвлөмж, зөвлөгөөг өгч ажилласан байна. Энэ давхардсан тоогоор 186 мянган жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч хамрагдсан байгаа.

Бид 20 оноос хойш бол үйл ажиллагаагаа бүрэн цахимжуулсан. Өөрөөр хэлбэл төсөл, сонгон шалгаруулалтыг бүгдийг нь бүрэн цахимжуулж, цахимаар хүлээж авч, хариуг нь цахимаар өгдөг болсон. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн тодорхойлолтыг ерөөсөө аж ахуйн нэгж 1-хэн минутын дотор өөрөө мэдээллээ оруулаад “Хур” системээр татвар, нийгмийн даатгал Сангийн яамнаас мэдээлэл нь ирээд л жижиг.../минут дуусав./

**О.Батнайрамдал:** Эрдэнэсайхан даргын микрофоныг өгье. Нэмж цаг өгье.

**Я.Эрдэнэсайхан:** Мөн зээлдэгчдийн бүх мэдээллийг Жижиг, дунд үйлдвэрийн веб сайт болон shilen.gov.mn дээр бүгдийг нь ил тод хэн гэдэг хүн хэдэн онд ямар зээл аваад өнөөдөр ямар ангилалд байгаа, хэдэн төгрөгийн үлдэгдэлтэй байгаа гэдгийг газарзүйн байршил дээр нь аймаг, сумаар нь гаргаад ингээд энэ манай веб сайт дээр бүрэн орчихсон байгаа. Өөрөөр хэлбэл, хэн ч, хаанаас ч хянах боломжтой болчихсон байгаа.

Мөн зээлдэгчдэдээ гар утасны аппликэйшн бий болгоод яг “reel time”-аар мэдээллээ би өнөөдөр хэдэн төгрөгийг төлөх вэ гэдгээ авч чаддаг болсон байгаа. Ингээд ил тод байдлаа сайжруулсан хүрээнд бол Авлигатай тэмцэх газар, мэргэжлийн байгууллага, төрийн байгууллагуудад ил тод байдлын үнэлгээ хийдэг, шударга байдлын үнэлгээ хийдэг. Ингээд 21-ээс 24 онд бол Жижиг, дунд үйлдвэрийн агентлаг бол тогтмол 1, 2 дугаар байранд мэргэжлийн байгууллагын үнэлгээгээр үйл ажиллагаагаа шилэн ил тод болгосон гээд явж байна.

Бид Монгол Улсын төрөөс баримталж байгаа урт, дунд, богино хугацааны бодлогын бичиг баримтууд дээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байгаа. Ингэхэд бол “Алсын хараа-2050” дээр бол 10 зорилт, 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан байгаа. Энийг бол та бүхэн маань мэдэж байгаа.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр дээр 19 зорилт, 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр бас ажиллаж байна.

Мөн таван жилийн үндсэн чиглэл дээр 1 зорилтыг хэрэгжүүлэхээр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр мөн 1 зорилтыг хэрэгжүүлэхээр үйл ажиллагаандаа тусгаад ажиллаж байгаа.

Мөн бид нарт нэн шаардлагатай, яаралтай шийдвэрлэх тулгамдсан асуудлууд байна.

Нэгдүгээрт, орон нутагт буюу аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар дээр жижиг, дунд үйлдвэрлэл хоршоог хариуцсан 1 мэргэжилтэн байдаг. Маш өндөр ачаалалтай ажилладаг. Ерөөсөө тайлангаа л өгдөг. Өөрөөр хэлбэл, бодлогын болон хэрэгжилтийнхээ үйл ажиллагаанд цаг зав гарах боломж бага байдаг. Хүний нөөцийн дутагдалтай байдаг.

Дээрээс нь Монгол Улсын хэмжээнд орон нутагт үйлдвэрлэв, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Бизнес инкубатор төв гээд 42 төв байдаг. Энэ маань өөрөө нэгдсэн удирдлага, зохион байгуулалт байхгүй. Зарим аймаг дээр 2, 3 байдаг. Ингээд жижиг, дунд үйлдвэрийн агентлагийг бол улсын хэмжээнд бодлого барьж байгаа ч зөвхөн 46 орон тоотойгоороо яваад байдаг. Бүтэц нь байгаа мөртөө уялдаа холбоо байхгүй байгаа. Үүнийг хууль, эрх зүйн хувьд шийдвэрлэх шаардлагатай байгаа.

Мөн уул уурхайн бус экспортыг дэмжих, экспортын төрөл, тоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатай байгаа. Мөн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага байгаа. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль дээр төсөл боловсруулаад явж байгаа гэсэн. Энэ дээр бол тэр нөгөө 2.5 тэрбум төгрөг хүртэлх энэ таазыг бол нэмэгдүүлэх шаардлагатай байгаа. 19 онд баталсан. Түүнээс хойш инфляц болон олон юм.../минут дуусав./

**О.Батнайрамдал:** Нэмэлт минут өгье Эрдэнэсайхан дарга.

**Я.Эрдэнэсайхан:** Мөн эх үүсвэрийг нэмэгдүүлэхээс гадна татвар, нийгмийн даатгалын таатай орчныг бий болгох ийм шаардлагууд үүсэж байгаа. Одоохон ганцхан яваад дуусах байх. Ингээд үзэхээр сангийн эх үүсвэрийг болж өгвөл улсын төсөв дээр Засгийн газрын тусгай сангаар бол Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэр бол улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, өмнө олгосон зээлийн эргэн төлөлт гэсэн энэ 4 эх үүсвэрээс л бүрддэг. Тэгэхээр улсын төсөв дээр бас тодорхой төсөв мөнгө тавьж өгөөч ээ гэдэг ийм санал бол сүүлийн жилүүдэд тогтмол явдаг. Ганц ч удаа мөнгө тавиагүй.

Дээрээс нь энэ жилийн хувьд бол 26 оны улсын төсөв дээр 55 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүл гээд нэмэлт даалгавар ирчихсэн. Энийг бол тодотгол орохоор бол хийх нэн шаардлагатай байгаа. Дээрээс нь 35.9 тэрбум төгрөгийг зээл олгох ийм шийдвэр гарсан. Орон нутгийн 7.9 дээрээ нэмээд бид нар 44 гаруй тэрбум төгрөгийг бол энэ жил зээл олгохоор ингээд түрүүний хэлснээр зарлаад ажиллаж байгаа.

Мөн дараачийн нэг асуудал бол Шинэ хоршоо гэж хөдөлгөөн бас 2024 онд үүссэн. Хоршооны бодлогын асуудал бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр, бодлогын хэрэгжилт нь Жижиг, дунд үйлдвэрийн газар дээр байдаг. Энд бас бүтцийн нэгж буюу хоршооны хөгжлийн газар байдаг.

Гэтэл Монгол Улсын Шадар сайд дээр ажлын алба байж байгаад зөвлөл болоод одоо буцаад ингээд ажлын албан дээр хэдэн хүнтэй, бас нэг төсөвтэй, орон тоотой ийм бүтэц бий болоод ингээд 2 ингээд салчхаад яваад байгаа. Энийг бол бүтэц, удирдлагын хувьд бас нэг болгох шаардлагатай гэж ингэж харагдаж байгаа.

Жижиг, дунд үйлдвэрийн газар дээр бол бодлогын хэрэгжилт нь манай дээр газар байдаг юм. Яаман дээр бол бодлого нь явж байдаг. Шинэ хоршоо гэж салгаад, Үндэсний зөвлөл байгаад тэгээд Шадар сайдын ажлын албан дээр бас 10 орчим хүнтэй, тодорхой төсөвтэй бас бүтэц яваад байгаа юм. Тийм.

Мөн бид нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, таван жилийн төлөвлөгөө, нэг жилийн төлөвлөгөө, Алсын хараа дээр ингээд даалгаврууд өгөгдчихдөг. Гэхдээ улсын төсөв дээр ерөөсөө мөнгө нь тавигддаггүй. Тэгээд хэрэгжилт нь нэхэгдээд байдаг ийм бас бодит шаардлага байгаа юм.

Тэгэхээр улсын төсвүүд дээр энэ нэгэнт даалгавар өгөгдсөн бол энэ даалгавраа биелүүлэх санхүүгийнх нь эх үүсвэрийг шийдэж өгөхгүй бол эх үүсвэрийг нь шийдээгүй мөртөө хэрэгжилтээ байшин барих төсвөө өгөөгүй тэгсэн хэр нь байшингаа бариагүй гэдэг ийм асуудлууд яригддаг юм.

Танилцуулж дууслаа. Баярлалаа.

**О.Батнайрамдал:** Эрдэнэсайхан даргад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асууж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү?

Батчимэг гишүүнээр тасалъя. Сэддорж гишүүний микрофон.

**Р.Сэддорж:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Бид хэд бол маш чухал ийм ажлын хэсэгт орчихсон. Энэ жижиг, дунд үйлдвэр гэдэг зүйл бас нэр хүнд нь жоохон энэ үгний талаасаа, нэрийн талаасаа жоохон нэр хүнд нь уначихсан ийм учраас энэ жижиг, дунд гэдгийг нийлүүлээд ийм нэр өөрчилбөл яадаг юм тээ? Жоохон нэр хүнд нь уначихсан нэртэй шүү дээ энэ чинь. ЖДҮ-ийн юу ч билээ тээ? Тэгээд энийг жоохон сэргээгээд нэрийг нь жоохон аятайхан нэр олбол Монгол хэл бол их баялаг хэл. Тийм учраас олдох байх гэж бодож байгаа.

100 тэрбум төгрөгөөр эх үүсвэрийг нэмэгдүүлэх дээр шууд дэмжих хэрэгтэй. Тэгээд энэ шиг ингэж нүдээ олсон энэ Монгол улсын энэ сангуудаас өөр сан бол байхгүй байх бараг. Энэ нь болохоороо тэр хоршоотойгоо л их нийцэж ажиллах хэрэгтэй байна. Энэтхэг улсад 3 сая хоршоо байдаг юм билээ. 300 хоршоологчдын банк байдаг юм билээ. Дээр үеийн манай хоршоологчдын банк гээд байсан, дампууруулсан. Тэгэхээр энэ бол маш чухал. Бид бол ингээд юмнуудаа цэгцтэй хийж чадахгүй байгаа, арга эвээ л олохгүй байгаа. Тэгэхээр ер нь тун удахгүй олох байх гэж бодож байна.

Аймгууд чинь бие даасан ингээд улсаас татаас авдаггүй аймгуудын тоо бол нэмэгдэх хандлагатай байна. Дорноговь ингээд ядаж нэг нэг уул уурхайн төслийг ингээд сайн дэмжээд эхлэх эхлэх юм бол аймгууд бол бие даасан улсын төсвөөс татаас авдаг биш улсын төсөвт орлого төвлөрүүлдэг ийм аймгууд бий болоод эхэлнэ. Тэгэнгүүт ингээд энэ ЖДҮ дээрээ мөнгө тавиад эхэлнэ. Энийгээ улам таслахгүй сайн цааш нь хийх хэрэгтэй.

Тэгээд энэ хоршооны бодлоготойгоо, хоршооны бодлого юутайгаа Засгийн газрын энэ бодлоготой маш сайн энэ юмнуудаа хоршиж холбож өгөх хэрэгтэй байна. Тэгээд та бүгдийн ажилд амжилт хүсье.

Мэдээж гадуур янз бүрийн юмнууд бас мэр сэр яригдаж байдаг тиймээ шударга явж байна уу, сонгон шалгаруулалт шударга уу гээд. Тэгээд энэ дээрээ бас улам цахимжуулах, улам анхаарах тал дээр та бүгд маань ажлаа зохицуулж төлөвлөөрэй. Тэгээд үүнээс илүү арга бол байхгүй. Ийм өндөр банкны хүүтэй байгаа үед бол. Тэгэхээр та нараас өөр ийм.../минут дуусав./

**О.Батнайрамдал:** Сэддорж гишүүнд нэмэлт 1 минут.

**Р.Сэддорж:** Тийм та нараас, энэ сангаас илүү ингэж ийм сайн хувилбар бол байхгүй. Энэ Хөдөө аж ахуйн газраар дамжина гэдэг бол, аймгийн Хөдөө аж ахуйн газруудаар дамжина гэдэг бол маш зөв. Тэр аймгийн орон нутгийн амьдралаа мэддэг, тэр орон нутагт юу эрхэлбэл энэ болох вэ гэдгийг мэддэг, зээлээ эргэж төлөх эсэхийг нь сайн мэддэг, энэ ч зээлээ төлж чадахгүй дээ гэдэг хүмүүст бол бараг л өгдөггүй. Тэгэхээр эргэн төлөлт ийм сайн байгаа чинь бол энэ юм хүмүүсээ зөв сонгож байна л гэсэн үг. Тэгээд аялал жуулчлалын тал дээр тэр зочид буудал ийм “hotel”, “motel” тэгээд тийм уушны газар, түр хоноглох газар, мөн цайны газар,

хуушуурын газар эд нар дээр сайн өгөх хэрэгтэй. Манайх аялал жуулчлалыг хөгжүүлэе л гэж байгаа бол ер нь эд нар л дутагдалтай байгаа гэдгийг хэлье.

**О.Батнайрамдал:** Сэддорж гишүүн үг хэллээ. Батчимэг гишүүний микрофоныг өгье.

**П.Батчимэг:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн манай энэ дэд хороо, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо байгуулагдсан нь бол бас санаандгүй тохиолдлын хэрэг биш л дээ. Тийм учраас ер нь Монгол улсын хэмжээнд хөдөө орон нутаг, Улаанбаатар хот, нийслэл энэ жижиг, дунд үйлдвэрлэл, бөөний зах зээл, бөөний төв энэ маш олон энэ ерөөсөө л голлох эдийн засгийг бас урагшлуулах, ард иргэдийн амьдралыг сайжруулах тал талын ач холбогдолтой энэ жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид гэдэг бол үнэхээрийн ёстой хамгийн онцгой анхаарах ийм салбар болчихоод байгаа юм.

Ард иргэд өнөөдөр юунаас, хаанаас өнөөдөр хэрэгцээгээ хангаж амин зуулгаа авч явж байна гэхээр л энэ жижиг, дунд үйлдвэрлэлийн эрхэлдэг энэ салбараас амьдарч байгаа ийм энэ нь бол нууцгүй шүү дээ. Тэгэхээр энэ салбарын хөгжлийг явж ирсэн түүх, ирээдүйд цаашдаа энэ салбар яаж хөгжих энэ том потенциал, хүртээмж, хэрэгцээ шаардлагыг бол яамны бүүр бодлого, газар бодлого болгож ажиллах ёстой. Одоогоор ер нь хууль боловсруулаад тэгээд энэ хуулийн хэрэгжилт энэ юм гэж ер нь байгаа юм уу? Энэ дээр ингээд харахаар Улсын Их Хурлын 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар энэ Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль гээд шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна гэх би энийг сайн ойлгохгүй байна л даа. Та тэрийг тодруулаад өгөөрэй.

Хоёрдугаарт нь энэ мэдээж юу байгаа л даа жижиг, дунд үйлдвэрлэл явуулж байгаа энэ аж ахуйн нэгж тэгээд энэ салбар жилээс жилд улам өргөжиж хөгжиж байгаа. Тэрийг дагаад энэ санхүүжилт, тэрний хүртээмж, зах зээлийн нөхцөл үнэнийг хэлэхэд бол өнөөдөр зах зээлийн энэ санхүүжилт, санхүүгийн нөхцөл байдал бол тааруу, татварын орчин бас тааруу тийм ээ, тэгээд төрийн үйлчилгээний чирэгдэл ихтэй энэ бүх олон асуудлуудаас улбаатай энэ салбарын хөгжил ер нь бол олигтой ч сайн урагшилж явж чадахгүй байгаа шүү. Энэ салбарт бизнес эрхлэгчдийн эрх ашиг, тэр энэ салбарын үйл ажиллагааг явуулахад тулгарч байгаа тэр олон асуудлуудыг бид хуулийн хүрээнд шийдчихдэг ийм шийдэлд хүрэх ёстой гэж би харж байгаа юм. Тэгэхээр энэ үйлдвэрлэл, технологийн төв.../минут дуусав./

**О.Батнайрамдал:** Батчимэг гишүүнд нэмэлт 1 минут өгье.

**П.Батчимэг:** Энд би 1 сая харлаа л даа. Үйлдвэр, технологийн төв байгуулна гэсэн байна. Тэгэхээр энийг бас тодруулаад өгөөч. Ямар учиртай энд үйлдвэр, технологийн төв байгуулах гээд ороод ирчхэв?

Дараагийн асуудал нь тэр гадаадад экспорт руу чиглэсэн бизнесийн юу бол бас хангалттай энд бас гайгүй явчихсан байна л даа. Жишээ нь зөндөө олон орнуудаар бас олон удаагийн үзэсгэлэн арга хэмжээнд оролцоод саяхан хүртэл бас Монгол Улсын Ерөнхийлөгч Итали улсад айлчлахад албан ёсны айлчлалаар тэнд бас манай жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарынхан оччихсон тэнд үзэсгэлэн гаргаад байж байсан. Манай хүнс Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан оччихсон ажиллаж байсан шүү дээ гэх мэтчилнээр энд зөндөө 29 удаагийн үзэсгэлэн, арга

хэмжээнд оролцсон л гэж байна 10 орчим байгууллага бас хамтран ажиллах гэрээ байгуулсан гэж байна. Энэ бол бас сайшаалтай сайн. Энд бол ажил явж байна. Тэгэхээр энийг цааш нь улам сайхан өр.../минут дуусав./

**О.Батнайрамдал:** Батчимэг гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Эрдэнэсайхан дарга.

**Я.Эрдэнэсайхан:** Батчимэг гишүүний асуултад хариулъя. Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газар.

Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийг бид нар 2019 онд Улсын Их Хурлаар батлуулсан Ганбаатар нарын гишүүд санаачлаад. Ингээд өнөөдөр бол хэрэгжилтийг нь хангаад ажиллаж байгаа. Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангаас зээл олгох журмыг Засгийн газраар батлуулсан. Энэ хүрээндээ бид нар бүхий л үйл ажиллагаагаа шилэн, ил тод болгоод явж байгаа. Эндээ бид нар 2023 онд хуулийн дагуу 2024 онд үнэлгээ хийсэн. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ. Үнэлгээгээр бол нэлээн өндөр хувьтай хуулийн биелэлт бол хангагдаад ажиллаж байна гэсэн ийм үнэлгээ гарсан учраас ямар ч байсан хуулийн хэрэгжилт бол сайн байсан юм байна гэдэг шийдвэр, үнэлгээ гарсан байгаа.

Жижиг, дунд үйлдвэрийн асуудал дээр ер нь бол зөвхөн жижиг, дунд үйлдвэрийн агентлаг биш маш олон төрийн байгууллагууд болон арилжааны банк, нийгмийн даатгал, татвар, улсын бүртгэл, Сангийн яам гээд олон байгууллагуудын хамтын ажиллагаа байж байж хөгждөг юм байна лээ олон улсын жишиг бол. Тэгэхээр өнөөдөр манайд бол бусад байгууллагуудын хамтын ажиллагаа бол сул байгаа. Өөрөөр хэлбэл, зөвхөн жижиг, дунд үйлдвэрийн агентлаг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ асуудлыг хариуцах мэтээр бас байгаад байгаа юм.

Тэгэхээр хэрэгжилт дээр энэ нөгөө Ерөнхий сайдын санаачилсан чөлөөлье гэдэг хөдөлгөөний хүрээнд ч гэсэн энэ бизнес эрхлэгчдийг илүү дутуу орон нутаг зөвшөөрөл нэрийн бичиг цаасаар дарамталдаг энэ юмнууд байхгүй болж байж жижиг, дунд бизнес өөрөө ингээд цаашдаа хөгжих олон шат дамжлагууд нь үүсэх юм. Тэгэхээр маш олон төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа дунд бас үр дүн гардаг тийм онцлогтой салбар юм.

Сэддорж гишүүний асуултад бас Сэддорж гишүүн маань аймгийн Засаг даргаар ажиллаж байсан. Яг Өмнөговь аймаг маш сайн дэмждэг. Өнөөдрийн байдлаар гэхэд 22 тэрбум төгрөгийг орон нутгийн эх үүсвэрээсээ өгчихсөн. Тухайн үед Засаг дарга байж байхад яг ингээд сайд, Засаг дарга, агентлагийн дарга ингээд гуравласан гэрээг байгуулаад Өмнөговийн аж ахуйн нэгжүүд бол өнөөдөр гэхэд өнгөрсөн жилүүдэд хүссэн болгон шаардлага хангаж байвал зээлээ авдаг болсон.

Тэгэхээр бид нар цаашдаа ер нь Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэн сангийнхаа эх үүсвэрийг нэмэгдүүлээд өгвөл жилд 1 удаа конкурс шиг зарладаг биш ийм олон шат дамжлагатай биш үнэхээр хэрэгжих төсөл л байвал тэрийг нь үнэлээд өгдөг энэ Солонгос, Японы жишиг рүү оруулж өгмөөр байгаа юм.

Өнөөдрийн хувьд бол төсөв мөнгө нь хүрэхгүй учраас ялт ч байхгүй тэр дундаас 10, 20-хон хувийг нь хангаж байгаа учраас шалгахаас өөр аргагүй

болчихоод байгаа юм. Гарааны нөхцөл нь ижил байх, ижил шаардлага тавих ийм шаардлагатай учраас цаг үеийн хувьд бол ийм 3 үе шаттайгаар тодорхой хугацаанд зарлаж, хүлээж аваад, хаагаад тэрийгээ шийддэг ийм шилжилтийн үед явж байгаа. Дэд хорооны даргын хэлсэнчлэн, гишүүдийн хэлсэнчлэн цаашдаа энэ сан тогтвортой ажиллаад эх үүсвэр нь хангалттай болоод ирвэл ерөөсөө жилийн туршид энэ бага хүүтэй хувийг өгдөг.

Тэгэхдээ бие даасан санхүүгийн бүтэц буюу бид нар сая тэр нөгөө хуулийн төсөл боловсруулаад бэлэн болоод байгаа гэдэг дээр бол Үндэсний баялгийн сангийн Хөгжлийн сангаас тодорхой хувийг буюу уул уурхайгаас орж ирж байгаа тэр орлогын тодорхой хувийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд тодорхой хугацаанд зээлнэ. Энэ тэртээ тэргүй арилжааны банкин дээр хэвтэж байгаа мөнгийг санд зээлүүлээд, аж ахуйн нэгжүүдэд өгөөд, татварын бааз суурийг нэмэгдүүлээд, ажлын байрыг нэмэгдүүлээд тодорхой хугацааны дараа сангаас буцаагаад улсын төсөв рүү авдаг ийм систем бий болгочихвол сан өөрөө зээлдэгчдэдээ зээлээ 20 оноос хойшоо шударга болгоод явж байна, барьцаа хөрөнгийг нь хангалттай авч байна. Тийм учраас эрсдэл байхгүй.

Тэгэхээр өөрөөр хэлбэл тэр Хөгжлийн санд байгаа, зүгээр байгаа мөнгийг сангаар дамжуулаад жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжих юм бол үйлдвэрлэл эрхлэгчид маань хангалттай эх үүсвэртэй болчихно. Улсын төсөв буцаагаад.../минут дуусав./

**О.Батнайрамдал:** Батчимэг гишүүн нэмэлт тодруулга.

**П.Батчимэг:** Эрдэнэсайхан даргаас би асуусан Үйлдвэр, технологийн төв гээд анхаарч байна уу та? Үйлдвэр, технологийн төв гэсэн өгүүлбэр энд явж байна. Энэ ямар учиртай төв байгуулах гэсэн санаа орж ирсэн бэ? Нэг.

Хоёрдугаарт, та Жижиг, дунд үйлдвэрлэлийн энэ газрын даргаар хэдэн жил ажиллаж байгаа вэ? Энэ салбарыг хөгжүүлэх, ирээдүйд жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын зах зээлийн тэлэлт, эрэлт, нийлүүлэлт, гадаад экспортын хэмжээ, тэрийг, түүнийг ихэсгэх тал дээр та ер нь яг дорвитой ямар ямар арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж төлөвлөж байгаа вэ?

**О.Батнайрамдал:** Батчимэг гишүүний асуултад тодорхой хариулъя. Эрдэнэсайхан дарга. Нэмэлтээр хариулах хүмүүс гараа өргөөрэй.

**Я.Эрдэнэсайхан:** Батчимэг гишүүний асуултад хариулъя. Миний бие 2018 онд 4 сард Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар анх томилогдож байсан. Ингээд яамны газрын даргаар 2 жил ажилласан. Дараа нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байгуулагдаад агентлагийн даргаар өнөөдөр 6 дахь жилдээ ажиллаж байна.

Хоёрт нь бид нар энэ олон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжих олон үйл ажиллагаа байгаа. Энийг аль нэгийг нь ингэж орхигдуулахгүйгээр аль болох энэ бага хүчээр дэмжиж ажиллахыг хичээж байгаа. Тэр дотроо ялангуяа илүү потенциалтай байгаа аж ахуйн нэгжүүдээ экспортод гаргахад нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр түрүүний хэлсэнчлэн гадаадад туршлага судлах, үзэсгэлэн худалдаанд оролцох, бараа, бүтээгдэхүүнээ танилцуулах, гадаад түнштэй болох, түрүүн дараачийн шат буюу нэрийн барааны дэлгүүртэй тэд нь дандаа Монгол

үйлдвэрлэв гэсэн дэлгүүртэй. Жишээлбэл, Канадад байгаа Монголд үйлдвэрлэв дэлгүүр маань гэхэд.../минут дуусав./

**О.Батнайрамдал:** Эрдэнэсайхан дарга нэмэлт 1 минут.

**Я.Эрдэнэсайхан:** Арай илүү потенциалтай буюу ноос, ноолуур, арьс шир голчилсон компаниудын 30 гаруй компанийн бүтээгдэхүүнийг 1 дэлгүүр дээр борлуулалт хийгээд ингээд явж байгаа.

Дараачийн арга хэмжээ бол аж ахуйн нэгжүүдийг илүү кластержуулах энэ шаардлага руу явах ёстой юм байна. Өөрөөр хэлбэл, дан дангаараа бүх аж ахуйн нэгж бүх юмаа жишээлбэл гутал үйлдвэрлэдэг компани байлаа гэхэд улнаас нь эхлүүлээд эцсийн бүтээгдэхүүн гарах хүртэл бүх юмаа дангаараа хийхлээр 1 үйлдвэрийн бүтээмж багасаад нөгөө нэгж бүтээгдэхүүний үнэ нэмэгдээд яваад байгаа юм. Тэгэхээр энэ Солонгос, Японы яагаад нэгж бүтээгдэхүүний үнэ бага байгаа вэ гэхлээр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид нь кластераар явдаг юу гэдэг юм энэ пиджакийг оёлоо гэхэд ханцуйг нь, эсгүүрийн 1 газар хийдэг, оёдлыг нь 1 газар хийдэг, товчийг нь 1 газар хаддаг тэгээд ингээд зэргэлдээ кластер үйлдвэрүүд байхлаар нэгж цаг хугацаанд гарах бүтээгдэхүүний гаралт нэмэгдэж байгаа юм. Ингэнгүүт бүтээгдэхүүний өртөг багасаад өрсөлдөх чадвартай болоод ингээд явж байгаа. Тэгэхээр.../минут дуусав./

**О.Батнайрамдал:** Нэмэлтээр Гэрэлзаяа дарга индэр дээр Жижиг, дунд үйлдвэрийн Газрын бодлого, зохицуулалтын газрын дарга Гэрэлзаяа Батчимэг гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

**А.Гэрэлзаяа:** Батчимэг гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, бизнес инкубатор төвүүдийг байгуулахаар зохицуулсан байгаа. Гэхдээ энэ дээр тавигдсан санхүүжилт нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр төсөвтэй мөртөө яг Улсын төсөв хэлэлцэх үеэр энэ төсөв мөнгө ингээд тавигддаггүй учраас одоо хүртэл ингээд нэмж байгуулсан юмгүй байна. Улсын хэмжээнд ер нь бол орон нутгийн хөрөнгө оруулалттай болон улсын төсвийн хөрөнгө оруулалттай байгуулагдсан төвүүд байдаг.

Гэхдээ нэгдсэн зохион байгуулалт байхгүй. Манай зохион байгуулалтад ордоггүй, бид нарын нэгдсэн удирдлагад ордоггүй ийм зохион байгуулалт яваад байгаа юм. Тэгээд Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд энэ зохицуулалтыг бид нар нэмж оруулахаар бас одоо энэ хуулийн төсөлд оруулаад явж байгаа.

Зүгээр энэ яагаад юунд хэрэгтэй юм бэ гэхээр энэ өөрөө шинээр байгуулагдаж байгаа гарааны бизнес эрхэлж байгаа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг гарааны дөнгөж эхэлж байх явцад нь сургалт, мэдээлэл өгөх, чадавхжуулах, дээрээс нь санхүүжилтийг нь давхар ийм.../минут дуусав./

**О.Батнайрамдал:** Гэрэлзаяа даргад нэмэлт 1 минут. Цагтаа багтааж хариулна шүү.

**А.Гэрэлзаяа:** Тэгээд боломж байвал өшөө бүүр дундын оффис буюу дундын үйлдвэрийн тоног төхөөрөмж тэнд нь байршуулчихсан, тэрийгээ ашигладаг байдлаар ийм зохион байгуулалттай Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих

төв байгуулахаар ийм Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байгаа.

**О.Батнайрамдал:** Батчимэг гишүүний сүүлийн тодруулга.

**П.Батчимэг:** Үйлдвэрлэл, технологийн төв гээд байгаа байхгүй юу. Үйлдвэрлэл, технологийн төв энэ танилцуулга дээр харж байна уу? Тийм, агентлаг байгуулах гэж байгаа юм уу энэ ямар утгаар, ямар агуулгаар энд орж ирсэн юм бэ?

**О.Батнайрамдал:** Гэрэлзаяа даргын микрофон.

**А.Гэрэлзаяа:** Тийм тэр нөгөө шинэ хоршоотой холбоотойгоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр бас шинээр тусгагдчихсан ажил байгаад байгаа юм. Техник дундын үйлчилгээний төв байгуулах юм байна. Тэр нь болохоор сумын юм уу, аймаг дундаа техникүүдээ дундаа ашиглах байдлаар төв байгуулах. Хоршоод тийм. Тэр нь болохоор өөр бизнес инкубатор төв тэр. Техник дундын үйлчилгээний төв болохоор хоршоотой холбоотой асуудал байна. Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр тусгагдчихсан. Бид нар болохоор төсөвт саналаа өгөөд л явж байгаа. Тийм тийм.

**О.Батнайрамдал:** Би бас хэдэн асуулт асууна. Монгол улсын эдийн засгийг ер нь бүтцээр нь аваад үзэх юм бол орлогыг уул уурхайн салбар дангаараа бараг бүрдүүлдэг харин ажил олгогч талаас нь аваад үзэх юм бол өнөөдөр сая презентациар гарч байна өнөөдөр Монгол улсад 110 мянга орчим идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд байгаагаас 82 мянга нь буюу 74 хувь нь жижиг, дунд үйлдвэрлэгчид. Тэгэхээр Монгол улсын хамгийн том ажил олгогч бол жижиг, дунд үйлдвэрлэл.

Уул уурхай орлого бүрдүүлдэг. Жижиг, дунд үйлдвэрлэл ажлын байрыг хангадаг ийм бүтэцтэй эдийн засаг. Гэтэл хамгийн их ажил олгож байгаа энэ жижиг, дунд үйлдвэрлэл дээрээ бид нар хангалттай анхаарлаа хандуулж чадаж байна уу, хангалттай бид нар дэмжлэг, тусламж үзүүлж чадаж байна уу гээд харах юм бол эсрэгээрээ харагдаад байна л даа. Өнөөдөр бид нар гараад иргэдтэй ялангуяа аж ахуй нэгжүүдтэй уулзах юм бол хамгийн түрүүнд яг энэ жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл л ярьж байгаа юм. Өнөөдөр арилжааны хүү ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэл дээр яг зарчмаар авах юм бол энэ чинь 20-30 хувийн хүүтэй байгаа шүү дээ. 20-30 хувийн хүүтэй байгаа гэр бүлийнхээ хамаг мөнгөө зараад бизнес хийхээр чинь ямар бизнес ашигтай ажиллах юм? Тэгэхээр жижиг, дунд үйлдвэрлэл гэдэг энэ консевт, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмждэг энэ консевт бол өөрөө хөгжиж байгаа, мөн хөгжсөн орнууд бүгдэд нь байдаг. Америкийн Нэгдсэн Улсаас авхуулаад, Канадаас авхуулаад байдаг л зарчим байхгүй юу. Заавал бодлогоор дэмжиж хамгийн том тэр ажил олгож байгаа бүлгээ дэмжих ёстой.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн сая сангийн асуудал ярьж байна л даа. Нийтдээ өнөөдрийн байдлаар 200 орчим тэрбум төгрөг эргэлдэж байгаа гэж ойлголоо. Чанаргүй зээлийн харьцаа түрүүн ярьж байснаас бол ер нь бага байна шүү дээ. 2-3. 2-3 гэдэг бол Монголын бүх зээлдэгчдийн багцыг аваад үзэхэд бол магадгүй хамгийн багад орох байх гэж бодож байгаа юм.

Ер нь том зээлүүдээ бодох юм бол жижиг, дунд төрлийн зээлийн эргэн төлөлт өөрөө сайн байдаг л даа. Энэ чинь ард нь 1 жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийн ард бүхэл бүтэн 1 гэр бүлийн амьдрал тэр чигээрээ явж байдаг байхгүй юу. 1 жижигхэн үйлдвэрлэл ажиллаж байгаа гэр бүл бүх зүйлээ, бүх хадгаламжаа тавиад тэндээсээ орлого олж амьдарч байгаа л хүмүүс байхгүй юу.

Тийм учраас чанаргүй зээл бага байдаг. Тэр хүмүүс яаж ийж байгаад бүх зүйлээ зарж байгаа ч хамаагүй зээлээ төлж амьдралаа авч явдаг. Тэгэхээр энийг төрөөс бид нар ямар нэгэн байдлаар дэмжих ёстой. Харин энэ төрийн бодлогыг хэрэгжүүлж байгаа чиг үүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийн газар болон Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан хамгийн нээлттэй, ил тод сонгон шалгаруулалт нь ямар нэгэн маргаангүй явж явах ёстой. Энэ өөрөө бүх жижиг, дунд үйлдвэрлэлийн газар болон Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангийн институцийн чадавх юм.

Энэ бол мэдээж маш олон асуудалтай тулгарч явж байгаад өнөөдөр сая та хэлж байна л даа Жижиг, дунд үйлдвэрлэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаас хойш 5 жилийн хугацаанд хэрэгжихдээ хэрэгжилт сайтай гэж нэгдүгээрт гарсан гэлээ. Хоёрдугаарт, энэ Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангийн зээл олголтын эргэн төлөлтөөс харагдаж байна л даа. Тэгэхээр энд сайшаалтай хандаж байна. Сайн. Энийг бид нар хамгийн гол нь энэ чинь нөгөө институцийн бэхжилт, цаашаагаа хэн нэгнээс хамаарахгүй, хэн нэгэн дарга, сайдаас хамаарахгүйгээр, хэн нэгэн огцом бодлогын өөрчлөлтөөс хамаарахгүйгээр тогтвортой явах энэ чиглэл рүү орох цаг нь бол болсон байна. Одоо бол шилжилтийн үе биш дараагийн шинэ үедээ гарах цаг нь болсон гэж эндээс харагдаж байна.

Урьд өмнөх Хөгжлийн банк болон Чингис бондын тэр замбараагүй зарцуулалтаас 123.9 тэрбум долларын өр төлбөртөө уначихсан байсан юм байна тийм үү? Энийг эргэн төлсөн гэж. 123.9 тэрбум долларын төгрөгийн энэ бондуудын өр төлөгдөнө гэдэг бол буцаад алдагдсан боломж нь энэ нь буцаад үйлдвэрлэгчдэд гарах боломжтой байсан эх үүсвэр гэсэн үг байхгүй юу. Энэ 2026 оны Монгол улсын төсөвт 55 тэрбум төгрөгийг жижиг, дунд үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн ЖДҮ сан маань улсын төсөвт орлого болж төвлөрүүлэх ийм санал орж ирж батлагдсан юм байна. Энэ зарчмын хувьд их буруу.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг бид нар яаж дэмжих вэ гэх юм бол буцаад энэ сан бие даасан өөрийн орлогоороо цаашаа бүрдүүлдэг бие даасан институц болгож хөгжүүлэх боломжийг нь олгох ёстой юм. Гэтэл буцаад 55 тэрбум улсын төсөвт эргэн төлөгдөнө гэдэг чинь тэгээд 55 тэрбум чинь буцаад зээл хэлбэрээр гарах боломжийг нь хааж байна гэсэн үг шүү дээ. Энэ чинь буцаад хүүтэй эргэн төлөгдөнө гэдэг чинь үржинэ гэсэн үг шүү дээ. Үржээд цаашаагаа улам томроод зээл болж эргэн төлөгдөх ёстой.

Өнөөдөр Монгол Улсад 23 тусгай сан байгаа юм. 23 тусгай сангийн өнөөдөр яг миний бодлоор, миний харж байгаагаар бол 2 хамгийн өндөр ач холбогдолтой цаашаагаа бие дааж хөгжүүлэх ёстой 2 санал байгаа. Бусад нь мэдэхгүй зүгээр.

Нэгдүгээрт, Боловсролын зээлийн сан. Боловсролын боломж олгодог энэ нь хэд мянга дахин үржиж ирдэг ийм сан улсын төсвөөс санхүүжиж явдаг.

Хоёрдугаарт нь бол Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан байхгүй юу. Хоёулаа маргаантай явж ирсэн. Хоёулаа маш их асуудал дагуулж ирсэн. Одоо

Боловсролын зээлийн сан цаашаа боловсролын боломж болгож очдог хөгжлийн том сан болж хувирах ёстой Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан бас улсын төсвөөс хэт хараат бус, дахиад хэлье бас нэг яамнаас, нэг сайдаас бас хэт хараат бус бие даасан институцийн хэмжээнд явах ёстой шүү.

Түрүүн хэлж байна лээ л дээ Жижиг, дунд үйлдвэрийн сангийн 3-5 хувийн зээлийн хүүг бас сайдын тушаалаар баталдаг гээд. Энэ сайдад хүү тогтоодог субъект бас биш байхгүй юу. Яах вэ одоо явж байгаа журмаараа сайд эцэслэн гарын үсэг зурдаг тийм л юм явж байгаа байх л даа. Энэ буцаад бие даасан институцийн хэмжээнд та нар өөрсдөө тогтоох ёстой юм. Өөрсдөө тогтоогоод явж байх ёстой.

Ер нь цаашдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны дэргэд сүүлийн 6 жил бол нэлээн сайжруулалт хийгдсэн байна. Ер нь цаашдаа та нар өөрсдийнхөө стратегийг тодорхойлох хэрэгтэй Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан бие даасан институц болох стратегиа тодорхойлж гаргаж ирэх хэрэгтэй.

Ингэхдээ миний харж байгаагаар бол өнөөдрийн байж байгаа байж байгаа мэдээлэл дээр үндэслэж байна шүү дээ. Хүнс, хөдөө аж ахуйн яам гэсэн ганцхан бүтцийн доор байж болохгүй байхгүй юу. Нэг яамнаас хамааралтай байж болохгүй. Өөрөө бие даасан институц болох хэрэгтэй. Бас улсын төсвөөс хэт хамааралтай байж болохгүй, улсын төсөв рүүгээ хамаг орлогоо тушаадаг байж болохгүй. Өөрөө олж байгаа орлогоо буцаад зээл хэлбэрээр гарч, санхүүжилтээрээ бие дааж явж байх хэрэгтэй. Өнөөдөр харьцуулах хэлбэр бол өнөөдөр ипотека байна. Ипотекийн зээл бол энэ чинь эргэн төлөлтөөсөө дахиад зээл ипотекаа гаргаад яваад байгаа шүү дээ. Яах вэ Монголбанкны доор гээд бас буруу институцийн доор аваачаад тавьчихсан. Монголбанк ипотекад ямар ч хамаагүй институц.

Гэхдээ өөр тохоочих институц байхгүй болохоор аваачаад нөгөө л Монголбанкаа аваачаад тавьчихсан. Тэгэхээр өнөөдөр яах вэ чиг үүргийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрлэлийн яамны яамны доор байгаад байна. Бойжоод авсан байна та нар. Одоо бойжоод хөлд орсон бол бие даах хэрэгтэй. Тэр 2026 оны төсөвт 55 тэрбум долларын, 55 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлнэ гэдэг бол буруу.

Харин цаашдаа гишүүд ч гэсэн бид нар энэ дээр анхааръя. Улсын төсвөөс тогтвортой нэмэлт санхүүжилт олгоод харин тэрний үр дүнг илүү арвижуулж олон төрлийн жижиг, дунд төрлийн зээл болгож гаргадаг ийм л бүтэц рүү орох ёстой.

Хоёрдугаарт, сонгон шалгаруулалт бие даасан явах ёстой. Өнөөдөр бол аймаг, орон нутгийн төсөвтэй холбож байгаа нь бол маш сайн. Энэ дээр хамгийн үлгэр жишээ нь сая Өмнөговь аймаг дээр гарч байна л даа. Яг зөв. Өмнөговь аймаг Монгол Улсын төсвийг уул уурхайд ялангуяа хамааралтай төсвийг бүрдүүлэгч гол аймаг. Тэгэхээр Өмнөговь аймгийн тэр уул уурхайгаас орж ирж байгаа орлогын нэг хэлбэр орон нутгийн төсвөөр дамжуулаад бусад жижиг, дунд үйлдвэрлэлдээ хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгож байна гэдэг бол баялгийн зөв хуваарилалтын механизм ажиллаж байна гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр энэ Өмнөговь аймгийн энэ сайн жишгийг бусад аймгууд дээр бүгд дээр нь хэрэгжүүлэх хэрэгтэй. 21 аймагт хэрэгжих хэрэгтэй. 28 аймгийн орон нутгийн төсөвтэй холбож өгөөд буцаад орон нутгийн иргэдээ жижиг, дунд

үйлдвэрлэл, аж ахуйн нэгжүүдийн хамгийн том ажлын байр бий болгож байгаа энэ хэлбэрээр л бид нар хөгжих ёстой.

Тийм болохоор зөвхөн улсын төсвөөр хамааралтай биш, орон нутгийн хөгжлийн төсөвтөө уяад ингээд явах ёстой. Харин сонгон шалгаруулалт хэд хэдэн дамжлагаар дамждаг юм байна тээ? Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын комиссоор ороод, дараа нь орон нутгийн комиссоор, хүмүүсийн оролцоотойгоор ороод газар дээр нь очиж, үзэж байж шалгардаг юм байна тийм үү? Маш зөв. Энэ мэдээлэл энэ алхам тутамдаа явж байгаа сонгон шалгаруулалтын процесс оролцогч талуудад бүгд нээлттэй, ил тод байх ёстой. Тэдний хяналт доор байх ёс тай юм. Энэ бол өөрөө бас олон улсад ч гэсэн хамгийн байдаг, ил тод асуудалгүй явдаг зарчим шүү дээ тээ?

Тэгэхээр яг иргэдийн оролцоо, тэр оролцогч талуудын буюу зээл авах хүсэлттэй иргэд маш их байгаад байна. Бид нар тэд нарын зээлээр нь хангаж чадахгүй байгаад байна шүү дээ тээ? Тэгэхээр тэр хүмүүс гомдоллоно шүү дээ. Тэгэхээр тэр хүмүүсийн оролцоог нь хангаж тэр сонгон шалгаруулалтын ил тод байдал дээр л оролцох ёстой юм. Тэгэхээр энэ байдал руу цаашдаа орж явах ёстой. Тэгж явж чадах юм бол Жижиг, дунд үйлдвэрлэлийн энэ сан бол Монгол Улсад бас жишиг сан болоод явах ёстой шүү.

Яагаад гэх юм бол энэний ард нь түрүүн хэллээ л дээ, 82 мянган аж ахуйн нэгжийн асуудал ярьж байгаа байхгүй юу. Энийг маш олон жижиг, дунд үйлдвэрлэлийн үйлдвэрлэл явуулдаг хүмүүс үзэж байгаа. Тэр хүмүүсийн горьдож байгаа найдлага юу вэ гэхээрээ энэ нь хөнгөлөлттэй зээл бидэнд хэзээ ирэх юм бол доо л гэдэг л найдлага байгаа шүү дээ.

Тэгэхдээ энэ дээр нэг асуултыг асууж байгаа юм. Сая жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль ялангуяа Улсын Их Хурал дээр бид нар энэ хуулийн хэрэгжилт хэрхэн хангах бэ, цаашдаа энэ хууль тэгвэл 6 жилийн туршид хангалт, хэрэгжилт сайтай байсан бол хэрхэн бас цаашаага сайжруулж болох юм? Ээ цаашаа Эрдэнэсайхан захирлаас асуух, даргаас асуух гээд байна л даа. Энэ цаашдаа шинэ бодлогын түвшинд гарч явахад та нар өөрсдөө хэрхэн харж байгаа юм? Хамтын ажиллагаа маш чухал. Олон улсын ингэж явсан маш олон жишиг байгаа. Олон улсын байгууллагууд бас энэ жишгүүдээ тайлбарлах, энэ жишгийг Монголын хөрсөн дээр буулгахад их нааштай ханддаг юм. Тэгэхээр эд нартай хэр бас хамтарч ажиллаж байгаа вэ? Улсын Их Хурлын зүгээс ялангуяа энэ дэд хорооны зүгээс бид бүхний ба бас тусалж дэмжих дэмжлэг та бас хаана байна гэж харж байгаа вэ? Асуулт асууж нэмж тодруулъя Эрдэнэсайхан даргаас.

**Я.Эрдэнэсайхан:** Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Үнэхээр бас яг зовлонг бүгдийг нь бас мэдэж байгаа, ойлгож байгаа учраас маш зөв саналуудыг тавьж байна. Үнэхээр олон улсад бол энэ жижиг, дунд үйлдвэрлэлээ дэмжиж байж чинээлэг дундаж давхраа бий болгож, тэгээд татварын бааз суурь нь нэмэгдэж, улсын төсөв нь эндээсээ арвиждаг. Тодорхой хугацаанд дэмжлэг шаардлагатай. Бид нар өмнө нь явж ирсэн туршлага бол тодорхой хугацаанд дэмжих гэж оролдсон. Гэхдээ эзэндээ очоогүй учраас өнөөдөр муугийн жишээнд ороод тэгээд нэр нь цэвэрлэгдэж бүрэн чадахгүй яваад байгаа. Сан бол цэвэр болсон. Гэхдээ энийг олон нийтэд хүргэх тал дээр бол бас учир дутагдалтайгаа ажиллаж байгаагаа хүлээн зөвшөөрч байна.

Тэгэхээр хуулийн хэрэгжилт бол маш өндөр хувьтай хангагдаж байгаа ч гэсэн одоо хуулиа сайжруулах нэн шаардлагатай байгаа. Түрүүний хэлсэнчлэн 2.5 тэрбум төгрөг хүртэл жилийн борлуулалтын орлоготой гэхлээр одоо бол үнэхээр бараг бичил нь орчхоод байгаа юм. Жишээ нь бид нар зүгээр Америктай харьцуулахад арай хол ч гэсэн Америкийнх бичил нь 100 сая доллароос доошоо орж байгаа юм. Тэгэхэд бид нарынх жижиг, бичил, дунд бүгд нийлээд 1 сая доллар. Өнөөдрийн ханшаар бол бүр 07 мянган долларын доошоо жилийн борлуулалтын орлоготой гэдэг бол үнэхээр учир дутагдалтай байгаа. Тэгэхээр энэ хууль дээр сайжруулах юмнууд бол нэлээн байгаа.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд хороо болон Улсын Их Хурал дээрээс бол хуулийн төслийг нь боловсронгуй болгож өгөөч, түрүүний таны хэлсэнчлэн бие даасан институц бий болгох, энэ нь өөрөө санхүүгийн байгууллага бий болоод ингээд зээлээ хараат бусаар олгоод явдаг ийм системийг бий болгож өгье гээд Бадамсүрэн сайд бол хуулийн төсөл ингээд боловсруулаад явж байсан. Одоо удахгүй Улсын Их Хуралд өргөн баригдах байх. Тэр дээр бол тусгагдаад явж байгаа юм.

Олон улсын байгууллагуудтай бол маш нягт хамтарч ажиллаж байгаа. Жайка, Европын сэргээн босголт хөгжлийн банк гэх мэтчилэн олон байгууллагууд бол яг энэ бид нарт туршлагаасаа хэлдэг юм бол жижиг, дундаа дэмж ээ. Жижиг, дунд дэмжиж байж хамгийн олон ажлын байр бий болно. Энийг дагаад зөвхөн эдийн засаг гэж харж болохгүй шүү. Нийгмийн маш олон асуудлууд, нөгөө гэр бүл салалт, нөгөө гэмт хэрэг багасалт, нөгөө орон нутаг руу шилжилт хөдөлгөөн гээд маш олон асуудлууд энэ ажилтай, орлоготой хүмүүс бол шийдээд явдаг юм. Түүнээс биш зөвхөн эдийн засгийн утгаар нь татвар бүрдэнэ, орлого нэмэгдэнэ гэж харж болохгүй. Цаана нь нийгмийн чинь маш олон асуудлууд бол шийдэгддэг юм гэдэг ийм зөвлөгөө өгдөг.

Тийм учраас бид нар олон улсын байгууллагуудтай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр хэрэгжиж байгаа төслүүдтэй бол хамтарч ажилладаг.

**О.Батнайрамдал:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Өнөөдрийн бас хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүддээ баярлалаа. Мөн Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар болон Төрийн нарийнд баярлалаа. Өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

13.27 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*

